



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.2, 6.3, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны баталсан “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаал, Хотын стандарт, хяналтын газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг “Маш сайн”, “Хэвийн” үнэлэгдсэн төрийн жинхэнэ албан хаагчдад олгох мөнгөн урамшууллыг үндсэн цалингийн 80 хүртэл хувиар тогтоож олгохыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээтэй танилцаж, хянан баталгаажуулж, журмын дагуу холбогдох арга хэмжээний саналыг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Үнэлгээний баг (Г.Энхээ)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ